

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД 2023 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргад хэрэгжүүлж ажиллахаар үүрэг болгосон 111 шийдвэрийн 199 заалтыг хяналтад авч, холбогдох журмыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн сан /unelgee.gov.mn/-д хугацаанд нь байршуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.


Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хяналтад авсан 111 шийдвэрийн 199 заалтын 162 (81.4 хувь) нь бүрэн хэрэгжсэн, 24 (12.06 хувь) нь хэрэгжих шатанд, 4 (2.01 хувь) нь хэрэгжилт хангалтгүй, 9 (4.5 хувь) нь хэрэгжилт тооцох хугацаа болоогүй заалт байгаа ба биелэлтийн дүнг дунджаар авч үзвэл **94.74** хувьтай буюу **4.73** оноогоор үнэллээ.

**2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЭРЭГЖИЛТИЙГ
ТООЦОХ ШИЙДВЭРИЙН ДҮНГ НЭГТГЭХ ХҮСНЭГТ**

Булган		Тогтоол, шийдвэр											2/2/2024
		Үүнээс											
		Нийт	Үүнээс										
Нийт	Нийт		УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Монгол улсын хууль	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ҮАБЗ-ийн зөвлөмж	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		111	111	5	17	5	14	32	28	6	4	0	0
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		199	199	10	44	11	32	43	43	8	8	0	0
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100 хувь /90-100/	162	162	6	43	11	25	33	32	5	7	0	0
	Хэрэгжих шатанд 70.0 хувь /50-89/	24	24	2	0	0	4	4	10	3	1	0	0
	Хэрэгжилт хангалтгүй 30.0 хувь /10-49/	4	4	0	1	0	0	2	1	0	0	0	0
	Хэрэгжээгүй 0.0 хувь /0-9/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	9	9	2	0	0	3	4	0	0	0	0	0
Биелэлтийн дүн /хувь/		94.7	94.7	95.5	98.4	100.0	95.9	93.3	91.4	88.8	96.3	#DIV/0!	#DIV/0!

Дээрх хүснэгтээс харахад тогтоол шийдвэрийн хэрэгжилт сайн буюу нийт хяналтад авсан шийдвэрүүдийн 81,4 хувь нь бүрэн хэрэгжиж үр дүнд хүрсэн, харин 12.06 хувь нь хэрэгжих шатанд буюу зохион байгуулалтын үйл ажиллагаа хийгдэж байгаа, харин 4.5 хувь нь аймагт хамааралгүй шийдвэрийн заалтууд багтаж байна. Хөрөнгийн эх үүсвэр, болон удирдлага зохион байгуулалтаас шалтгаалж 4 заалт хэрэгжилт хангалтгүй байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтууд 94.74 хувийн биелэлттэй байгаа нь 2021 онтой харьцуулахад гүйцэтгэлийн хувиар, 2022 онтой харьцуулахад хяналтад авагдсан заалтын тоогоор өссөн байна.



Тогтоол шийдвэрийн биелэлтийг нарийвчлан авч үзвэл Монгол Улсын 14 хуулийн 32 заалт 95.9 хувь, УИХ-ын 5 тогтоолын 10 заалт 95.5 хувь, УИХ-ын байнгын хорооны 17 тогтоолын 44 заалт 98.4 хувь, Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 11 заалт 100.0 хувь, Засгийн газрын 32 тогтоолын 43 заалт 93.3 хувь, Засгийн газрын хуралдааны 28 тэмдэглэлийн 43 заалт 91.4 хувь, Засгийн газрын 6 албан даалгаврын 8 заалт 88.8 хувь, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 4 зөвлөмжийн 8 заалт 96.3 хувьтай тус тус хэрэгжжээ.



Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд тэр дундаа Монгол Улсын хууль болон Улсын Их хурлын тогтоолуудын биелэлтийг хангах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нэлээдгүй үр дүнд хүрсэн байна гэж үзлээ.

Тухайлбал: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, жил бүр үр дүнг тооцон тус хуралдаанаар хэлэлцүүлж байна.

2022 онд “Аймгийн төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөрийг ИТХ-ын ээлжит хуралдаанаар батлуулсан ба 2023 онд 3 зорилт 17 арга хэмжээнд ... төгрөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.

2022 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд аймгийн төсвийн 48.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар түр хамгаалах байрыг ашиглалтад оруулан үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.

Төрийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан 22 заалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албанд нэг бүрчлэн хариуцуулж, аймгийн албан ёсны цахим хуудас (www.bulgan.gov.mn)-д шинээр цэс үүсгэн тухай бүр мэдээллийг бүрэн оруулж, шинэчлэх үүргийг тухайн мэдээлэл хариуцагч албан хаагч нарт өгснөөр үйл ажиллагааны ил тод байдал өмнөх оноос сайжирсан байна.

Ойн тухай хуулийг хэрэгжүүлэн ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний шороон зурвас байгуулах ажилд орон нутгийн төсөвт 75.0 сая төгрөг батлууллаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 700665 ширхэг мод тарьж, аймгийн ногоон байгууламжийн хэмжээг 15.6 хувиар нэмэгдүүлсэн байна.

2023 онд Биеийн тамир, спортын салбарт 1.6 тэрбум төгрөгийн оруулалт хийгдэж, 2022 оны мөн үетэй харьцуулахад 3-с, 4 дахин нэмэгдсэн. Мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сургууль, цэцэрлэгүүдийн 77.5 хувь нь ариун цэврийн байгууламжтай болоод байна.

Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэхээр 5 зорилт 34 арга хэмжээ бүхий “Нээлттэй Булган” хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Дүгнэлт:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн явцад сар бүр болон хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилт удааширсан, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг илрүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу гүйцэтгэлийг сайжруулан ажилласнаар тайлангийн чанар сайжирсан эерэг үр дүн гарч байна.

2022 оны жилийн эцсийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтээс зохион байгуулалтын хувьд аймгаас шалтгаалах зүйлгүй, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээс үүдэн хэрэгжих боломжгүй хэд хэдэн шийдвэрүүдэд хасуулах санал өгч, хяналтаас хасуулсан ба нэг удаагийн буюу зохион байгуулалтын чанартай шийдвэрийн биелэлтүүд хангагдсан нь 2022 оны жилийн эцсийн тайлангийн харьцуулсан үзүүлэлтээс харагдаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар аймагт даалгасан 111 шийдвэрийн 199 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Засгийн газрын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д хугацаанд нь байршуулж, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан бичгээр хүргүүллээ.

Нэгдсэн зөвлөмж:

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 94.74 хувьтай байгаа хэдий ч агентлаг, сум, байгууллагын удирдлагууд шийдвэрийн хэрэгжилтийг мэдээлэх, тайлагнахад үйл ажиллагааг дурдсан, тооцоо судалгаа байхгүй, гарсан үр дүнг мэдээлэхгүй, хувийг хэт өсгөх зэрэг зөрчил дутагдалд анхаарах;

Тайланг хэтэрхий нуршсан, үр дүнг бус үйл ажиллагааг тоочон тайлагнасан тохиолдлууд давтагдсаар байгаа тул тайланг график, хүснэгт ашиглаж, тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр гарсан гол үр дүнг товч тодорхой тайлагнах;

Хариуцсан салбарын тогтоол шийдвэрийн биелэлтийг харьяа газар, хэлтсүүдээс нэгтгэн авахдаа тухайн тайланд дүн шинжилгээ, боловсруулалт хийсний үндсэн дээр, хэлтсийн даргад танилцуулж, хэлтсийн даргын гарын үсгээр баталгаажуулан, эцсийн тайланд өгөх;

Аймгийн Засаг даргын 2021 оны А/207 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 8-р зүйлийн 8.7 дахь заалт Захиргааны байгууллага бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон сүүлийн 3 жил тасарсан болон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, хэрэгжилт тогтмолжсон шийдвэрүүдийг дотооддоо хяналтад авч хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтыг хүчингүй болгох, хяналтаас хасах

тухай саналыг жилийн эцсийн тайлангийн хамт хүргүүлэхэд анхаарч ажиллах. Тус журмын дагуу тайлагналтыг сайжруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Тухайлбал: Нэг ажлыг хэд хэдэн заалтын биелэлтэд тайлагнах, тухайн заалтад хамааралгүй биелэлт гаргах, хэт нурших, зэрэг нийтлэг алдаа дутагдлыг дараа дараагийн тайланд засаж сайжруулан, үйл ажиллагаандаа анхаарч, хариуцлагатай тайлагнахыг хариуцсан салбарын газар, хэлтсүүдэд анхааруулж байна.